



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/М7

Улаанбаатар хот

Дүүргийн хариуцлагатай эргүүл, жижүүр
томилон ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Тулгар төрийн 2234 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 819 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 114 жил, Ардын хувьсгалын 104 жилийн ойн хүрээнд баяр наадмын амралтын өдрүүдэд дүүргийн хариуцлагатай эргүүл жижүүрээр дүүргийн онцгой комиссын гишүүдийг 2025 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 09.00 цагаас 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 09.00 цаг хүртэлх хугацаанд томилсугай.

2. Байгууллага бүрд хариуцлагатай эргүүл жижүүр томилон ажиллуулахыг аж ахуйн нэгж байгууллагын дарга, эрхлэгч нарт, цахилгаан шугам сүлжээнд үүсэж болзошгүй саатал, гэмтлээс урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг зохион байгуулан, томилгоот бүрэлдэхүүнээ тодотгон бэлэн байдлаа хангаж ажиллахыг Эрчим хүчний салбар (С.Алтанхүү), Улаанбаатар Төмөр замын Эрчим хүч, ус хангамжийн 1 дүгээр ангийн хэсгийн мастер (Я.Түдэв), хэрэглээний халуун усны уурын зуухны хэвийн үйл ажиллагаа, багаж, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг "Илч-Орд" ОНӨААТҮГ (Д.Гантулга), Улаанбаатар Төмөр замын Барилга засвар ашиглалт үйлчилгээний ангийн Багахангайн зуухны механик (Б.Мөнх-Адъяа), цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах хэвийн найдвартай ажиллагааг хангахыг Ус суваг ашиглалтын товчоо (Ц.Болд), гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг цагдаагийн хэлтэс (цагдаагийн хурандаа Т.Лхагвасүрэн)-т, гамшиг, аюулт үзэгдэл ослоос урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллахыг Онцгой байдлын хэлтэс (хурандаа Б.Цогбадрах)-т тус тус үүрэг болгосугай.

3. Дүүргийн хариуцлагатай эргүүлээр ажиллах онцгой комиссын гишүүдийн нэрсийг нэгдүгээр, шаардагдах хөрөнгийн төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

4. Эргүүл жижүүрээр ажиллахад шаардагдах 208,800 (хоёр зуун найман мянга найман зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д, онцгой комиссын гишүүд, аж ахуйн нэгж байгууллагуудын хариуцлагатай эргүүл жижүүрүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан тухай дүн мэдээг илтгэх хуудсаар 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 10.00 цагт танилцуулж, санхүүгийн тайланг 2025 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн дотор Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг Онцгой байдлын хэлтэс (Б.Цогбадрах)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL\2025 он ажил\захирамж

12250104-1

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн
А/197 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт


ХАРИУЦЛАГАТАЙ ЭРГҮҮЛ, ЖИЖҮҮРЭЭР АЖИЛЛАХ
АЛБАН ТУШААЛТНЫ НЭРС

Д/д	Овог, нэр	Албан тушаал	Утасны дугаар	Эргүүлээр ажиллах хуваарь	
				Эхлэх	Дуусах
1.	Л.Санжийжамц	Засаг даргын Тамгын газрын дарга	88111277	2025.07.10	2025.07.11
	М.Мөнхболд	Онцгой байдлын хэлтэс Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад	96008619		
2.	Б.Цогжавхлан	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга	99819181	2025.07.11	2025.07.12
	Ц.Мягмарсүрэн	Онцгой байдлын хэлтэс Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, дэслэгч	86131110		
3.	Д.Оюунгэрэл	Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын хэлтсийн дарга	88022444	2025.07.12	2025.07.13
	Б.Мөнх-Эрдэнэ	Онцгой байдлын хэлтэс Ангиллын сургалт сурталчилгаа, бие бүрэлдэхүүний сургалт хариуцсан мэргэжилтэн, дэслэгч	88224791		
4.	Б.Отгонжаргал	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга	99059921	2025.07.13	2025.07.14
	Б.Баяртуяа	Нийгмийн даатгалын газрын дарга	96966916		
5.	М.Уранцэцэг	Улсын бүртгэлийн хэлтсийн дарга	99016039	2025.07.14	2025.07.15
	Б.Батзориг	Хоёрдугаар хорооны Засаг дарга	99105204		
6.	Д.Энхтайван	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга	89020587	2025.07.15	2025.07.16
	Д.Цэвэгдорж	Хурлын төлөөлөгч	88032850		
7.	А.Отгонжаргал	Хөдөө аж ахуйн тасгийн дарга	94646442	2025.07.16	2025.07.17
	Д.Ууганбаатар	Хурлын төлөөлөгч	86091074		
8.	Г.Дагвадорж	Дүүргийн менежер	99831606	2025.07.17	2025.07.18
	Ц.Мягмарсүрэн	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга	95199889		

Хяналт шалгалтаар ажиллах хариуцлагатай эргүүл жижүүр нь дүүргийн онцгой комиссын даргад нөхцөл байдлыг утсаар илтгэж ажиллах.

Онцгой байдлын хэлтсийн шуурхай албаны 62-60 УБЧ автомашинтайгаар эргүүл хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэх ба Засаг даргын Тамгын газрын жижүүр дээр өглөө 09 цагт рапортын дэвтэрт тэмдэглэл хөтлөн дараагийн жижүүрт хүлээлгэн өгнө.

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 04 дугаар сарын 04-ны өдрийн
8/117 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



ЭРГҮҮЛ ЖИЖҮҮРЭЭР АЖИЛЛАХАД ШААРДАГДАХ
ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ		Нэг бүрийн үнэ	Бүгд
			өдөрт	нийт		
1.	Шатахууны зардал (А-92)	литр	10	80	2610	208.800
Нийт дүн						208.800